



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит бус V хуралдааны тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ: Хотын стандартыг батлах тухай

ТАНИЛЦУУЛСАН НЬ: Р.Дагва /Нийслэлийн Засаг даргын цахим хөгжил, хууль, эрх зүй, төрийн үйлчилгээний асуудал хариуцсан орлогч/

ҮҮРЭГ БОЛГОХ НЬ: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д ДААЛГАХ нь:

1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус V хуралдаанаар 9 бүлэгт хамаарах нийт 38 хотын стандартуудыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр редакцын засвартайгаар баталсантай холбогдуулан Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газар болон мэргэжлийн холбоодтой хамтран арга зүйн зөвлөгөө авч хянаж, редакцын засвар хийх;

2.2022 онд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулахаар төлөвлөж буй хотын бусад стандартуудыг Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газар болон мэргэжлийн холбоодоос мэргэжил, арга зүйн зөвлөгөө, санал авч хамтран ажиллах, мөн тэдгээр стандартуудыг хэрэгжүүлж ажиллах аж ахуйн нэгж, иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, улсын хэмжээнд мөрдөгдөж буй стандартуудтай уялдуулах, давхардсан зохицуулалт тусгахгүй байх зэргийг анхаарч ажиллахыг тус тус үүрэг болгов гэжээ;

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН АЖЛЫН АЛБА



1110100066